



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 07 сарын 22 өдөр

Дугаар А/458

Алтай хот

Гэрээ шууд байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэг, Засгийн газрын 2021 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 124 дүгээр тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 21 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хантайшир уулын аймгийн 100 жилийн ойн бэлтгэл хангах ажлын хүрээнд аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 19,470,000 (арван есөн сая дөрвөн зуун далан мянга) төгрөгийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэх “Говь-Алтай аймгийн түүх” судалгааны бүтээлийг хийлгэх ажлын гэрээ шууд байгуулан гүйцэтгүүлэх эрхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Батзориг)-т олгосугай.

2.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Батзориг)-т үүрэг болгосугай.

3.Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Г.Хурцгэрэл)-т тус тус даалгасугай.

ОРЛОГЧ Г.ЧИНБАТ

